

**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,  
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,  
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,  
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2024.07.08 № 03/5874  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Гомдол хянасан тухай**

Танай байгууллагаас зарласан ТБ/20240102111 дугаартай “Автомат гал унтраах систем нийлүүлж суурилуулах” тендер шалгаруулалтад оролцсон “Нью телеком” ХХК-аас гаргасан гомдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид “хууль” гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.8 дахь хэсэг болон Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам”-д заасны дагуу оролцогчоос ирүүлсэн гомдлын хүрээнд хянан үзлээ.

“Нью телеком” ХХК-ийн гомдолд тус компанийн тендерээс барааны дэлгэрэнгүй танилцуулгыг монгол хэлээр ирүүлээгүй, тендер шалгаруулалтын баримт бичгийн өгөгдлийн хүснэгтэд ТШЗ 21.1 гэсэн заалт байгаагүй учраас тус тендерт нийлүүлэх тоног төхөөрөмжийн үнийн саналыг нэгтгэсэн байдлаар илгээсэн тул захиалагчийн шийдвэрийг хянан үзэхийг хүссэн байна.

Гомдолд дурдсан үндэслэлийн дагуу “Нью телеком” ХХК-д хүргүүлсэн захиалагчийн 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн 17/3379 тоот мэдэгдлийг үзэхэд тендер шалгаруулалтын зааварчилгаа (ТШЗ) 12.1, 21.2 гэсэн заалтыг үндэслэн татгалзсан байх бөгөөд үүнд өгөгдлийн хүснэгт гэсэн зүйл дурдагдаагүй байна.

1. “Нью телеком” ХХК-ийн тендерийн үнийн саналын задаргааг хянан үзэхэд захиалагчийн бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан нэр төрлөөр ирүүлээгүй нь тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 21.1-д “Барааны үнийн задаргаанд багц тус бүрийн барааны нэр төрөл тус бүрээр нэгж болон нийт үнийг тусгаж ирүүлнэ” гэж заасан шаардлага хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

2. “Нью телеком” ХХК-ийн тендерийн “3.автомат гал унтраах...” нэртэй файлын 18-96 дугаар хуудас дахь барааны дэлгэрэнгүй танилцуулгыг Монгол орчуулгагүй ирүүлсэн нь тендер шалгаруулалтын баримт бичгийн тендер шалгаруулалтын зааварчилгааны 12.1-д “Тендер шалгаруулалтын зарлал, баримт бичиг, урилгыг гадаад хэлээр давхар нийтэлсэн эсэхээс үл хамааран тендер шалгаруулалтын баримт бичиг, тендер шалгаруулалттай холбогдох албан бичиг, захидал, бусад баримт бичиг, оролцогчийн ирүүлэх тендер монгол хэлээр байх ба өөр хэлээр үйлдсэн тендер, түүний доторх баримт бичиг, мэдээллийг орчуулсан

орчуулгыг тендерт оролцогч бэлтгэн ирүүлнэ” гэж заасан шаардлага хангаагүй гэж татгалзсан захиалагчийн шийдвэр үндэслэлтэй байна.

Тендер шалгаруулалтыг хуульд нийцүүлэн цааш үргэлжлүүлэхийг үүгээр мэдэгдье.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасны дагуу захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг түдгэлзүүлсэн шийдвэрийн хугацаа үүгээр дуусгавар болно.

Хувийг: “Нью телеком” ХХК-д.

ТӨРИЙН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА



Ж. ГАНБАТ